



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 14-ний өдөр

Дугаар A/358

Мандалговь

Г Гэрээ байгуулах тухай Т


Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ын 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А/277 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх "Эрдэнэдалай сумын Цэцэрлэгт хүрээлэн"-ийн тохижилтын ажлын гүйцэтгэгчээр "БАТЛЮКС" ХХК-ийг сонгон 258,793,440 (Хоёр зуун тавин найман сая долоон зуун ерэн гурван мянга дөрвөн зуун деч) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Улсын төсөвт тухайн онд баталсаны дагуу 2018 онд 134,800,000 (нэг зуун гучин дөрвөн сая найман зуун мянга), 2019 онд 123,993,440 (нэг зуун хорин гурван сая есөн зуун ерэн гурван мянга дөрвөн зуун деч) төгрөгийн санхүүжилтийг олгох талаар гэрээнд тусгасугай.

Гурав. Батлагдсан зураг төсвийн дагуу Эрдэнэдалай сумын Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "БАТЛЮКС" ХХК-ны захирал (Г.Цэрэндорж)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-д, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж)-д, Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар)-д нарт тус тус үүрэг болгосугай.



488010177